

АГУУЛГА

| | |
|--|----|
| БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА | 3 |
| 1.1. ОРШИЛ | 3 |
| 1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ | 3 |
| 1.3. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН | 4 |
| БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ | 5 |
| 2.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | 5 |
| 2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ашиглалт | 8 |
| БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ | 10 |
| БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ | 12 |
| 4.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ | 12 |
| 4.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ | 12 |
| БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ | 15 |
| 5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ | 15 |
| 5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 16 |
| 5.1.2. Байгаль орчны нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө | 19 |
| 5.1.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 21 |
| 5.1.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө | 21 |
| 5.1.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | 22 |
| 5.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 22 |
| 5.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 25 |
| 5.1.8. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ | 27 |
| 5.1.9. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | 29 |
| 5.2. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ) | 30 |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ | 32 |
| 5.3. | 32 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл | 5 |
| Хүснэгт 2. Төслийн байршлын солбицол | 5 |
| Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим ба ашиглалтын бодит цаг | 8 |
| Хүснэгт 4. Нээх үндсэн малталтуудын ажлын хэмжээ | 9 |
| Хүснэгт 5. А. Уулын малталт нэвтрэлтийн нийт ажлын хэмжээ | 9 |
| Хүснэгт 6. Б. Уулын малталтын нийт хэмжээ, малталтын төрлөөр | 9 |
| Хүснэгт 7. Төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт | 10 |
| Хүснэгт 8. Нөлөөллийг тооцох аргачлал | 12 |
| Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур | 13 |
| Хүснэгт 10. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ .. | 13 |



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---------------------------------------|---|
| Зураг 1. Төслийн байршлын зураг | 6 |
| Зураг 2. Төслийн талбайн зураг | 7 |

БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

“Ди Жи Ти Энд Эм” ХХК нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах MV-013378 тусгай зөвшөөрлийн дугаартай “Булган уул” хайлуур жоншны уурхайгаас далд аргаар олборлосон хүдрийг бутлан, ангилах дамжлагаар, бүхэллэг хэсгийг гар аргаар ангилан ФК-75 маркийн баяжмал гаргаж экспортлохоор төлөвлөж байна. Харин үлдсэн бага агуулгатай хүдрийг “Гок Булган уул” ХХК-ийн тунаан баяжуулах үйлдвэрт зах зээлийн ханшаар нийлүүлнэ. Тус уурхай нь одоогоор үйл ажиллагаа явуулаагүй ба 2023 оноос эхлэн 4 жилийн хугацаанд хүдрийн нөөцийг ашиглахаар уулын ажлыг далд аргаар олборлохоор төлөвлөсөн байна.

Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний “Экологийн бүтээмж” ХХК болон Ди Жи Ти Энд Эм” ХХК -ийн хооронд байгуулсан гэрээний дагуу “Булган” уул хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах “Булган” уул хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2022 онд “ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

Бид бүхэн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, тушаалуудыг үндэслэн боловсруулав.

1.3. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН

Ажлын зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- a) Ажиллагсад бүх байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, үр чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- b) Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
- c) Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
- d) Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖГ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг: БОМТ-г доорх үндсэн 2 бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан авч үзэв. Үүнд:

- a) Байгаль орчны менежмент төлөвлөгөө: Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- b) Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

2.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох

Төслийн зорилго: “Ди Жи Ти энд Эм” ХХК-ний хэрэгжүүлж буй “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн гол зорилго нь уул уурхайн салбарт амжилттай ажиллан, Монгол улсын эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, ашиглалт, үйлдвэрлэлийн шинэ техник технологийг нэвтрүүлэх, орон нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, хайлуур жоншны ордын талбайд ашигт малтмалын ажлыг чанарын өндөр түвшинд, үнэн зөв тогтоон гүйцэтгэж, ашиглалтын явцад байгаль орчинд ээлтэй, хаягдал багатай техник, технологи, тоног төхөөрөмжөөр харилцан ашигтай үйл ажиллагаа явуулах, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

Төслийн үндэслэл: Уурхайгаас олборлосон хүдрийг бутлан, ангилах дамжлагаар, бүхэллэг хэсгийг гар аргаар ангилан ФК-75 маркийн баяжмал гаргаж экспортлохоор төлөвлөж байна. харин үлдсэн бага агуулгатай хүдрийг “Гок Булган уул” ХХК-ийн тунаан баяжуулах үйлдвэрт зах зээлийн ханшаар нийлүүлнэ. Тус уурхай нь одоогоор үйл ажиллагаа явуулаагүй ба 2022 оноос эхлэн 4 жилийн хугацаанд хүдрийн нөөцийг ашиглахаар уулын ажлыг далд аргаар олборлохоор төлөвлөсөн байна.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл


| Аж ахуйн нэгжийн нэр | “Ди Жи Ти энд Эм” ХХК |
|--|--|
| Улсын бүртгэлийн дугаар | 9011483108 |
| Регистрийн дугаар | 5853583 |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | MV-013378 |
| Хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6 бичил хороолол, Хасбаатар, 24, 106, |
| Утас | +976-99082707 |

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт L-49-18-А хавтгай дахь “Булган Уул” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2009-2010 онд геологи, хайгуулын нарийвчилсан судалгаа хийж, үр дүнгийн тайланг Монгол улсын ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, бодит болон боломжит нөөцийг тогтоон батлуулж, 2008 оны 3-р сарын 18 ны өдөр АМГ-аам 13378А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.


Төслийн талбайн байршил: Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 380 км, Хэнтий аймгийн төв болох Чингис хотоос зүүн хойш 52 км, багийн төвөөс 17.2 км зайтай оршино.

Хүснэгт 2. Төслийн байршлын солбицол

| д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|-----|--------|----|----|---------|----|----|
| 1 | 110 | 58 | 41 | 47 | 37 | 34 |
| 2 | 110 | 58 | 41 | 47 | 37 | 50 |
| 3 | 110 | 59 | 05 | 47 | 37 | 50 |
| 4 | 110 | 59 | 05 | 47 | 37 | 34 |



Зураг 1. Төслийн байршлын зураг



Зураг 2. Төслийн талбайн зураг

2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АШИГЛАЛТ

Төслийн хүчин чадал

Уурхай нь жилд 20000 тн хүдэр олборлон, гар аргаар бүхэллэг жонш ялгаж, экспортонд гаргахаар тооцсон байна. Хоногийн хүчин чадал 20000 тн : 220 хон=91 тн байна. Ээлжинд 30.3 тн, цагт 3.79 тн хүдэр гаргана.

Уурхайн хүчин чадал ажиллах хугацааг харгалзан тооцож, жилд ажиллах хоногийг дараахү байдлаар тооцож гаргав. Уурхай нь бүтэн жилийн турш хөдөлмөрийн хуулийн дагуу 7 хоногт 5 ажлын өдөр, хоногт 3 ээлжтэй бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг, газрын дээрх ажилчдад 8 цагаар тогтоосон горимоор ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим ба ашиглалтын бодит цаг

| Д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Далд уурхайд | Газрын дээр |
|-----|------------------------------------|-------------|--------------|-------------|
| 1 | Календарь хоног | хоног | 365 | 365 |
| 2 | Баяр ёслол | хоног | 11 | 11 |
| 3 | Амралт | хоног | 104 | 104 |
| 4 | Засвар үйлчилгээ | хоног | 24 | 24 |
| | Цаг агаараас хамаарсан сул зогсолт | хоног | 6 | 6 |
| | Уурхайн цэвэр ажлын хоног | хоног | 220 | 220 |
| 5 | Хоногийн ээлжийн тоо | - | 3 | 3 |
| 6 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 7 | 8 |
| 7 | Ээлжийн цаг ашиглалтын коэффициент | - | 0.8 | 0.8 |
| 8 | Уурхайн хоногт ажиллах бодит цаг | цаг | 16.8 | 19.2 |
| 9 | Уурхайн жилд ажиллах бодит цаг | цаг | 3696 | 4224 |

Уурхайн ашиглалтын хугацаа

Уурхайг эхний жилд байгуулж, нээх үйл ажиллагаа явагдах тул үндсэн ба бэлтгэл малталтын ажлууд голдож хийгдэх тул хүдэр олборлолтыг төлөвлөөгүй болно. Уурхайн ашиглалтын хугацаа нь 4 жил байх ба 1 дэх жилд нь уурхайг байгуулж нээх, 4 дэх жилд нь уурхайн хаалт нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна.

Ордыг нээх ба ашиглах дараалал

Ордыг нээх талбайн сонголт

Ордын талбайн газрын гадаргуугийн рельеф нь тэгшивтэр, хүдрийн биет нь босоо уналтай, зүүн хойноос баруун урагш чиглэн сунаж тогтсон зэргийг үндэслэж, ордыг босоо гол амаар нээх шаардлагатай гэж дүгнэв. Босоо гол амыг ордын төв хэсгээс хойш 35 м-ын зайд далайн түвшнээс дээш 1072 м-т байхаар сонголоо.

Нээх малталтуудыг нэвтрүүлэх

Ордыг нээх малталтуудыг дараах дарааллаар нэвтрүүлнэ.

1. Босоо гол амыг газрын гүнд 1000 м-ийн түвшин хүртэл 72 уртааш метр нэвтрэнэ. Сүүлийн 5 м нь ус хуримтлуулах зориулалттай зумф байх болно.
2. Босоо гол амны 1005 м-ийн түвшнээс зүүн урд зүгт чиглүүлэн 17 м хүлээн авах хэсэг буюу камер нэвтрэнэ.
3. Цааш судлын судалд хөндлөн чиглэлд урд зүгт чиглүүлэн 45 м квершлаг нэвтэрч хүдрийн судалд хүргэснээр ордыг нээх болно.

Хүснэгт 4. Нээх үндсэн малталтуудын ажлын хэмжээ

| Д/д | Малталтын нэр төрөл | Урт /м/ | Талбай /м/ | Эзлэхүүн /м³/ | Жин /тн/ |
|----------------|---------------------|---------|------------|---------------|----------|
| Үндсэн малталт | | | | | |
| 1 | -Ствол | 72 | 9.95 | 716 | 1790 |
| 2 | -квершлаг | 45 | 5.22 | 235 | 587 |
| 3 | -уурхайн хашаа | 40 | 5.22 | 209 | 523 |
| 4 | -камер | 37 | 5.22 | 193 | 482 |
| 5 | Дүн | 194 | - | 1353 | 3382 |

Ордыг ашиглах дараалал

Ордын нөөцийн блокийн төв хэсэгт нь нээх тул ашиглах дараалал нь төвөөс 2 жигүүр рүү гэсэн байдалтай байна. Блокыг олборлож байх явцад дараа дараагийн бэлтгэл ажлууд хийгдсэн байх ёстой. Блокыг олборлож байхад дараагийн блокуудад хийгдэх ажил нь блокыг бэлтгэх, блокыг нээх ажлууд зэрэг явагдаж байна. Өөрөөр хэлбэл блокыг олборлож дуусахад тасралтгүй буюу цикл ажиллагааг алдагдуулахгүйн үүднээс дараагийн ажил явагдах блок бэлтгэгдсэн байна.

Уулын ажлын нийт хэмжээ

Хүснэгт 5. А. Уулын малталт нэвтрэлтийн нийт ажлын хэмжээ

| Д/д | Уулын цулын нэр | Малталтын төрөл | Урт /м/ | Эзлэхүүн /м³/ | Жин /тн/ |
|-----|-----------------|-------------------|---------|---------------|----------|
| 1 | Хоосон чулуу | -Ствол | 72 | 716 | 1790 |
| | | -квершлаг | 45 | 235 | 587 |
| | | -уурхайн хашаа | 40 | 209 | 523 |
| | | -камер | 37 | 193 | 482 |
| | | дүн | 194 | 1353 | 3382 |
| 2 | Хүдэр | -скреперийн штрэк | 323 | 1526 | 4120.2 |
| | | -тээврийн штрэк | 339 | 1770 | 4779 |
| | | Востоющий | 461 | 1826 | 4930.2 |
| | | дүн | 1123 | 5122 | 13829.4 |
| | | | 1317 | 6475 | 17211.4 |

Хүснэгт 6. Б. Уулын малталтын нийт хэмжээ, малталтын төрлөөр

| № | Малталтын нэр төрөл | дугаар | Урт /м/ | Талбай /м/ | Элэхүүн /м³/ | Жин /тн/ |
|------|---------------------|--------|---------|------------|--------------|----------|
| 1 | Ствол | 1 | 72 | 9.95 | 716 | 1790 |
| 2 | Уурхайн хашаа | 1 | 40 | 5.22 | 209 | 523 |
| 3 | Камер | 1 | 20 | 5.22 | 104 | 260 |
| | | 2 | 17 | 5.22 | 104 | 222 |
| | Дүн | - | 37 | 5.22 | 89 | 482 |
| 4 | Квершлаг | 1 | 45 | 5.22 | 235 | 587 |
| 5 | Тээврийн штрэк | 1 | 339 | 5.22 | 1770 | 4779 |
| 6 | Восстоющий | 1 | 65 | 4 | 257 | 694 |
| | | 2 | 67 | 4 | 265 | 716 |
| | | 3 | 66 | 4 | 262 | 707 |
| | | 4 | 66 | 4 | 262 | 707 |
| | | 5 | 71 | 4 | 282 | 761 |
| | | 6 | 64 | 4 | 253 | 683 |
| | | 7 | 62 | 4 | 245 | 662 |
| | Дүн | - | 461 | 4 | 1826 | 4930 |
| 7 | Скреперийн штрэк | 1 | 263 | 4,72 | 1241 | 3356 |
| | | 2 | 60 | 4,72 | 283 | 764 |
| | | Дүн | - | 323 | 4,72 | 1526 |
| Бүгд | | | 1317 | - | 6475 | 17211.4 |

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРЙЛОЛТ

Хүснэгт 7. Төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

| Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт | |
|--|---|
| Физик газарзүй | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт орших бөгөөд геоморфологийн мужлалаар Хэнтийн уулархаг бүсийн зүүн урд төгсгөл Төв азийн их муж, Монгол Дорнодын мужийн Улз Хэрлэнгийн дэд мужид хамаарна. Байгалийн газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их муж, Онон-Улз голын сав газрын хөмбөн-цулдан нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн муж, хээр 10%-иас бага, мараа марз 10%-иас бага бүхий умард хуурай хээрийн районд орно. Бүс бүслүүрийн хувьд хуурайсаг, үлдмэл бэсрэг нам уулс, толгод бүхий тэгширлийн гадарга зонхилсон, өндөрлөг тал бөгөөд зундаа халуун хуурай ба өвөлдөө хахирдуу, хүйтэн хуурайдуу, хавар нь хахир, намар нь нарлаг сэрүүн зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай. Төслийн нутаг дэвсгэр нь Хэрлэн сумын нутагт орших бөгөөд төслийн нутаг дэвсгэрт хамгийн ойр орших цаг уурын харуул нь Хэрлэн суманд байрладаг байна. |
| Уур амьсгалын нөхцөл | Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Төслийн талбайн уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй, эрс өөрчлөгдөж байдаг. Өвөл: Өвлийн саруудад цаг агаар гол төлөв цэлмэг тогтуун байдаг. Хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж агаарын температур -24.3°C хүйтэн, үнэмлэхүй хамгийн бага нь -46°C хүрч хүйтэрсэн байна. Энэ улиралд ойролцоогоор 60-70 мм хур тунадас унах ба харьцангуй чийгшил 60-70% байдаг. Дунджаар 11-р сарын 26-наас 3-р сарын 4 –нийг хүртэл тогтвортой цасан бүрхүүл тогтох ба 15 см хүртэл зузаантайгаар тогтдог (Намхайжанцан, 2002). Хавар: Хаврын улиралд агаарын температурын хэлбэлзэл ихсэж, салхины хурдны их утга ажиглагдан, чийг багасч, агаар хуурайшдаг. Мөн цаг агаар огцом өөрчлөгдөж тогтворгүй байдаг байна. Салхины дундаж хурд 4.2 м/с, хамгийн ихдээ 24 м/с хүрдэг. Зун: Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын агаарын дундаж температур 19.3°C байна. Үнэмлэхүй хамгийн их температур 39.0°C хүрч халсан байна. Жилд дунджаар багадаа 250 мм хур тунадас унадаг ба зуны саруудад хур тунадасны дийлэнх хэсэг нь 70 % буюу 175 мм хур тунадас унадаг бөгөөд үлдсэн 30% нь өвлийн улиралд цас хэлбэрээр унадаг байна (National Agency of Meteorology, Hydrology and Environment Monitoring, Ulaanbaatar 2005). Дулааны улиралд дунджаар 60 хоног бороотой байдаг (Намхайжанцан, 2002). Намар: Намрын улиралд агаарын даралт ихэсдэг боловч нарны эрчим буурдагтай холбоотойгоор хур тунадасны хэмжээ багасдаг. Иймээс хур тунадасны хэмжээ намрын эхний сард 4.3 мм хүртэл буурдаг. |
| Ус | Засаг захиргааны хувьд тус талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт, ус зүйн үүднээс Номхон далайн ай савд багтах бөгөөд голын сүлжээний нягтшилаар нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт 0.05-0.10 км/км ² байдаг. Голын нийлбэр урсац нь 5-25мм, ууршилт 200-400 мм, гадаргын урсац 25-50мм байна. Газар нутгийн нийт чийгшил 250мм-ээс дээш, усны гадаргаас уурших ууршилт 400-600мм бөгөөд гол мөрний усны горим нь хаврын шар ус, зуны хурын усаар тэжээгддэг ба үүнээс газар доорхи усаар 20%, цасны усаар 25%, хурын усаар 55% тэжээгдэнэ. Голын хатуу урсацын жилийн хэмжээ 1-2тн/км ² , голын усны булингаршил нь 100-200г/м ³ байна. Борооны үерийн хамгийн их урсацын модуль нь 0.2-0.4км ² л/с байгаа нь дунд зэргийн үзүүлэлт юм. Төслийн талбай нь хүн ам сийрэг суурьшсан, төвөөс алслагдсан бүс нутагт |

| | |
|------------------------------|--|
| | <p>оршино. Газрын гадаргын хувьд ДТДээш 1250 м-т өргөгдсөн намхан уул, толгод бүхий тэгширлийн гадарга зонхилсон өндөрлөг газар юм. Өөрөөр хэлбэл тус нутаг дэвсгэр нь олон зүйлийн өвс ургамал бүхий дугуй хэлбэрийн намхан толгод, алгуур намссан тал юм.</p> <p>Хэнтийн нурууны зүүн хойд төгсгөл хэсэгт байрлах жижиг гүвээ толгодоос тогтох ба хамгийн өндөр цэг нь Сүүжийн өндөр далай түвшинээс дээш 850м, ус зүйн хувьд байнгын урсгал ус тусгай зөвшөөрөл бүхий талбайд байхгүй, ордоос зүүн урагш 50 гаруй км-т Хэрлэн гол, баруун урагш 5км-ийн зайд Бүрдний нуур хэмээх ширгэдэг нуур оршдог. Харин жижиг цөөрөм, тогтмол ус нилээдгүй байдаг. Төслийн талбай орчимд нутгийн иргэдийн гаргасан гар худаг байх бөгөөд төслийн хэрэгжилтийн үед дээрх худгуудаас усны хэрэгцээг хангахаар төлөвлөсөн байна.</p> |
| <p>Хөрсөн бүрхэвч</p> | <p>“Ди Жи Ти энд Эм” ХХК-ийн “Булган уул” хайлуур жоншны орд нь Хэнтийн нурууны урд үзүүрт, түүний хаяа уулсын системд байрлах бөгөөд судалгааны талбай орчмын тэгш талд хүрэн шороон хөрс зонхилох бөгөөд нам өндөртэй цав толгодоор сайр чулуурхаг нимгэн хүрэн хөрс, нам уулсын ёроолоор тохиолдох хуурай, сайр жалга, хонхор хотос газруудаар нугархаг хар хүрэн хөрс, голын татмын орчмын хонхор газруудаар чийгэрхэг, нугархаг хөрс элбэг тохиолдоно. Судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийн онцлог нь ойролцоох нам уулс болон өндөрлөг газруудаас зөөгдөн ирж хуримтлагдах пролюви, делювийн хайрган хурдас дээр хүрэн хөрс ялгаран хөгжсөн зүй тогтолтой байна.</p> <p>Хүрэн хөрс: Нам өндөртэй цав толгодын бэл, тэдгээрийн хоорондох уудам хөндий, хоолой орчимд илэрнэ. Тус хэв шинжийн хөрсний ургамал бүрхэвч нь үетэнт, агь-үетэнт, алаг өвс- үетэнт хуурай хээрийн ургамал зонхилно. Хуурай хээрийн бүсд орших учир чийгийн хангамж дутагдалтай, хөлдөлт бага гүнд явагддаг, зуны хур бороонд хөрсний өнгөн 20-30 см гүн хэсэг норж чийглэгддэг тул карбонат хуримтлалын давхарга нягтарч хатуурсан байдаг.</p> <p>Ялзмаг хуримтлалын А давхарга нь бараандуу болон хүрэн өнгөтэй, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй, жижиг үйрмэг хайрга сайр чулуутай, шилжилт нь өнгөөр тод ялгарч харагддаг. Энэ давхаргын дор карбонат хуримтлалын В (ВС, С) давхарга шууд илэрдэг. Шилжилтийн В давхарга нь цайвар бор өнгөтэй, нягтавттар, зузаавтар, эртний цэвдэг болон мараалаг шинж тод илрэлээ олсон байдаг. Карбонат хуримтлалын ВС, С давхарга нь тод бор, цайвар өнгөтэй, нягтарч хатуурсан байдаг.</p> |
| <p>Ургамал</p> | <p>Бидний судалгааны ажил гүйцэтгэсэн газар нь хээрийн бэлчээр бөгөөд 2 бүлгэмдэлд 19 овгийн 41 төрлийн нийт 54 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-2, сөөглиг-1, сөөгөнцөр-4, олон наст өвс-37, ганц ба хоёр наст-10 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.</p> <p>Булган уулын эргэн тойронд ургамлан нөмрөг харьцангуй тогтвортой, хэвийн ба жилийн дөрвөн улиралд ашиглаж байсан бэлчээрийг хавар, намрын бэлчээрт ашиглах нь илүү тохиромжтой байна. Ургамлын арвийн үнэлгээний хувьд зонхилогч, дэд зонхилогч ургамлууд нь sor2-sor1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй байна. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг нь /Stipa capillata, Cleistogenes squarrosa, Artemisia frigida/ бүрдүүлж буй ба арвийн хувьд sor2-sor1 үнэлгээтэйгээр тархаж буй ба энэхүү үнэлгээгээр энэ бэлчээрийг хэвийн гэж үзэв. Бүлгэмдлийн нийт ургамлын 70% нь ид цэцэглэлтийн үедээ буюу ургамалжилтын аспект нь цагаан шаргал өнгийг үүсгэж байсан. Ургамлын дундаж өндөр 7 см, Ургац 152.3-273.7-кг/га.</p> <p>Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөгөн ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, ганц ба хоёр наст ургамлын тэвгэн найлзуур доод дэд ташингийг бүрдүүлж байна. Бүлгэмдэлд байгаа ургамлын хамгийн өндөр нь /Stipacapillata-үслиг Хялгана,Agropyron cristatum- саман Ерхөг/ байлаа.</p> |

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

4.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хүснэгт 8. Нөлөөллийг тооцох аргачлал

| | |
|--------------------------------|---|
| Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3 | Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа) |
| Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3 | Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан) |
| Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3 | Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой) |

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур

| Төрөл/үнэлгээ Шалгуур | Төрөл/үнэлгээ Шалгуур | | |
|---|---|--|--|
| М: Хэмжээ, тархалт | | | |
| Түвшин -1 | Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд | | |
| Түвшин -2 | Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд | | |
| Түвшин -3 | Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд | | |
| Нөлөөллийн түвшин | | | |
| Бага зэргийн нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд бага | Богино хугацааны | Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой |
| Дунд зэргийн нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг | Дунд хугацааны | Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой. |
| Томоохон нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд их | Урт хугацааны | Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой |
| S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт | | | |
| Үнэлгээ= 1 | Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд | | |
| Үнэлгээ =2 | Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст | | |
| Үнэлгээ =3 | Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан | | |
| F: Давтамж буюу магадлал | | | |
| Үнэлгээ= 1 | Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй | | |
| Үнэлгээ =2 | Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой | | |
| Үнэлгээ =3 | Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно | | |
| Нийт түвшин=M x S x F | Үнэлгээ | Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ | |
| Нөлөөллийн түвшин бага | <6 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | |
| Нөлөөллийн түвшин дунд | 6-18 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | |
| Нөлөөллийн түвшин өндөр | >18 | Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | |
| Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой. | | | |
| Үр дүнтэй (зэрэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна | | | |

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

Хүснэгт 10. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

| Байгаль орчны хүчин зүйлс | Эрчим | | Тайлбар |
|--------------------------------------|-----------|---|--|
| | M x S x F | Нөлөөллийн үнэлгээ, эрчим | |
| Агаарын чанарт | 3x1x3 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | <ul style="list-style-type: none"> Төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд явах машинууд олон салаа зам гаргаж газрын гадарга талхлах, тэдгээрийн хөдөлгөөнөөс агаарт тоос дэгдэх |
| Дуу чимээнд үзүүлэх нөлөө | 1x2x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | <ul style="list-style-type: none"> Төслийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс дуу шуугиан үүсэж, орчинд тархах |
| Газрын гадаргад үзүүлэх нөлөө | 1x1x3 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | <ul style="list-style-type: none"> Барилга угсралтын үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөр газрын гадаргад нөлөө үзүүлнэ. |
| Хөрсөнд үзүүлэх нөлөө | 1x2x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | <ul style="list-style-type: none"> Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх, газрын гадарга, хөрсөн бүрхэвчид элэгдэл, эвдрэл үүсэх |

| | | | |
|---|-------|---|---|
| | | | <ul style="list-style-type: none"> Түүхий эдийн тээвэрлэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд өртөх, физик шинж чанар өөрчлөгдөх |
| Ургамлын бүрхэвчид үзүүлэх нөлөө | 2x2x2 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | <ul style="list-style-type: none"> Төслийн барилга байгууламж, тулгуур шон угсрах, шинэчлэх үйл ажиллагаанд ойр ормын ургамлан нөмрөг талхлагдах, устаж үгүй болох Төслийн бүхий л үйл явц, түүний хог хаягдал, зам зэрэг үйл ажиллагаанаас буй болох тоосжилт нь ургамал нөмрөг дээр бууж хуримтлагдах |
| Усан орчин | 1x1x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | <ul style="list-style-type: none"> Авто засварын газар болон авто машинаас шатахуун болон шатах тослох материал асгаран хөрсөн бүрхэвчээр дамжин гадаргын болон газрын доорх усанд нэвчих бохирдол үүсэх Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдал зэргийн үлдэгдэл угаагдан хөрс, газрын хэвлийг бохирдуулах улмаар гүний усыг бохирдуулах |
| Амьтны аймаг | 3x1x3 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | <ul style="list-style-type: none"> Шувууд өндөр хүчдэлд цохиулж тоо толгой хомсдох Засвар үйлчилгээ, барилга угсралтын үед ажиллах тээврийн хэрэгсэл, техникуудийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих Зэрлэг амьтдын амьдрах таатай орчинд сөргөөр нөлөөлөх, нүүдлийн замд саад хийх |

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Ди Жи Ти Энд Эм” ХХК нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлах MV-013378 тусгай зөвшөөрлийн дугаартай “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн 2023 оны БОМТ-ний хүрээнд хэрэгжүүлэх ажлын нийт зардлын дүн урьдчилсан байдлаар 9 876.9 мян.төгрөг байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийн хүрээнд хийгдэх бүхий л үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг чухал баримт бичиг юм. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын нийт зардлыг урьдчилсан дүнгээр 1 486.0 мян.төгрөг байхаар төлөвлөвөө.

5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|-------------------------|-----------------------|----------------------|--------------------------------|--|
| Агаар орчин | | | | | | |
| Төслийн үйл ажиллагаа болон задгай талбай, машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэж агаарын орчныг бохирдуулах | Уурхай, овоолго, зам талбайн усалгаа, норм, горимыг сар улирлаар оновчтой тогтоох | Төслийн талбайд | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS ISO4227:2002 Хүрээлэн буй орчны агаарын чанар, хяналтын төлөвлөгөө, MNS 6063 :2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих |
| | Уурхайн ашиглалтын замаас гадна олон салаа зам гаргахгүй байх, дотоод замуудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах | Төсөлд ашиглах замуудад | 500.0 | 500.0 | 2023 онд | |
| | Төслийн талбайд тоосжилтын түвшин болон ширхэглэгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтмол хянаж, агаарын чанарын стандартын шаардлага хангаж буйд хяналт тавих хяналтын цэгүүдийг бий болгох хэрэгтэй | Төслийн талбайд | Дотоод төлөвлөгөөгөөр | | Ашиглалтын жилүүдэд | |
| | Далд уурхай болон цехэд ажиллах ажилчдыг тоосны нөлөөллөөс хамгаалах, машин техникийн дотоод орчны битүүмжлэлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлаар хангах | Ажлын талбайд | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | |
| Машин механизмын дотоод шаталтат хөдөлгүүрээс хорт хий ялгарах | Төслийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг оношилгоонд оруулах | Тээврийн хэрэгслүүдэд | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | |
| | Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс ялгарах хийн хаягдлын хэмжээнд хяналт тавьж утааны шүүлтүүр тавих, тос маслыг тогтоосон мот/цаг тутамд сольж байх | Тээврийн хэрэгслүүдэд | 30.0 | 300.0 | 2023 онд | |
| Уурхайн үйл ажиллагаанаас их хэмжээний дуу шуугиан үүсэх | Дуу шуугиан ихтэй орчинд ажиллах үед ажилчдыг чихэвч болон бусад төрлийн аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгслүүдээр хангах шаардлагатай | Ажлын талбайд | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | |



| | | | | | |
|--|---|---|---|----------|---|
| | | | | | арга, |
| Усны нөөц, чанар | | | | | |
| Ордыг ашиглах явцад ил уурхайн ухааш, хаягдал чулуулгийн гадаад овоолгоос урсац үүсэх, их хэмжээний аадар бороо, үерийн улмаас угаагдал үүсэн гадаргын усыг бохирдуулах | Уурхайн хөрс, чулуулгын овоолго, ухааш, нүүрсний овоолго зэрэг урсац үүсэж болзошгүй хэсгүүдийн гадна талаар суваг, шуудуу татах, далан хаа лт сэтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байх, цаг уурын урьдчилсан мэдээ мэдээллийг тогтмол авч болзошгүй аюул эрсдэлийн үед бэлэн байх | Уурхайн хэсэг, гадаад, дотоод овоолго хамаарна. | Дотоод төлөвлөгөөгөөр | 2023 онд | Усны тухай хуулийн 21-р зүйл |
| Уурхайн үйл ажиллагааны үед техник хэрэгслийн ШТМ газрын хөрсөнд алдагдах, улмаар хур борооны усаар угаагдан шингэн газрын доорх болон гадаргын усыг бохирдуулах болзошгүй | Уурхайн дэвсгэр талбайд ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах Хуурай сайр, голдрилын ойролцоо автомашин, техник хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэхгүй байх | Хүнд машин техник, тээврийн хэрэгслүүд | Дотоод төлөвлөгөөгөөр | 2023 онд | Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм, MNS 4628:1998 Шатахуун түгээх станц. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага. |
| Хөрс, газрын гадарга | | | | | |
| Уурхай, овоолго, засварын талбай, бутлан, ангилах цех баригдах хэсэгт хөрс эвдрэх, дарагдах | Эвдрэлд өртсөн талбайн 10-аас багагүй хувьтай дүйцэх ногоон байгууламж байгуулах | Төслийн талбайд | Нөхөн сэргээлт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан. | 2023 онд | MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. MNS 5850:2006 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. |
| Уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлт, автомашины хөдөлгөөнөөс хөрс эвдрэлд өртөх, бохирдох | Уурхайн тээвэрлэлтийн замын чиглэл батлах, чиглэл, хурд заасан тэмдэг байршуулах | Төслийн ашиглалтын зам дагуу | Агаарын чанарын хэсэгт тусгагдсан. | 2023 онд | |
| Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах | Төсөлд ашиглагдах хүнд механизм, тээврийн хэрэгслийн зогсоол, засварын цэг, тос тосолгооны материал солих талбайг хатуу хучилттай болгох | Засварын талбай | Дотоод зардал | 2023 онд | |
| | Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх | Засварын талбай | 200.0 | 200.0 | |
| Хөрс хатуу, шингэн хаягдлаар бохирдох | Хог хаягдал ангилан хаях сав байршуулах, байгальд хог хаясан тохиолдолд хууль журмын хүрээнд шийдэх, эзэн холбогдогчгүй хог | Төслийн талбайд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд | 2023 онд | |



“ДИ ЖИ ТИ ЭНД ЭМ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | | | | | |
|--|---|---------------------------------|-----------------------|-------|----------------------|---|
| | хаягдлыг бага дээр нь тогтмол түүж цэвэрлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. | | тусгасан. | | | |
| Ургамлан бүрхэвч | | | | | | |
| Малчин өрхүүдийн бэлчээрийн нутаг хумигдах | Малчин өрхүүдийг зөв бэлчээрийн менежментийг төлөвлөхөд нь мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авахад тусалж хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд өвсөн тэжээл, отор, нүүдэл хийхэд санхүүгийн оролцоонд дэмжлэг үзүүлэх. | Малчин өрхүүдэд үзүүлэх дэмжлэг | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | MNS4918-2008.2.х Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага |
| Амьтны аймаг | | | | | | |
| Амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол буй болох | Биотехникийн арга хэмжээ авах/ Өвс, тэжээл, мөс, цас тавьж өгөх / | Орон нутгийн хэмжээнд | 500.0 | 500.0 | Ган, зудтай жилүүдэд | Нийгмийн хариуцлагын хүрээнд, Амьтны тухай хууль |
| НИЙТ (мян.төг) | | | | | | 1 500.0 |

5.1.2. Байгаль орчны нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө

Далд уурхайн аргаар олборлолт хийх нөхцөлд газрын гадаргын эвдрэл харьцангуй бага байдаг ба нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн олборлолт дууссаны дараа уурхайн босоо амууд, барилга байгууламж, хоосон чулуулгын овоолго, зам, барилга байгууламж зэргээр эвдэгдсэн газруудад хийж гүйцэтгэнэ.

“Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох тул үндсэн малталтуудыг битүүмжлэн хаах ба хуучин 1970-аад оны үед үүссэн ил уурхайн ухашыг олборлолтын үед гарсан хоосон чулуулгаар дүүргэж зохих стандартын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх орон нутагт хүлээлгэж өгөх учиртай. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд техникийн болон биологийн нөхөн сэргээлт, нөхөн сэргээлтийн хяналт мониторинг гэсэн хэсгүүдээс бүрдэх ба нөхөн сэргээлтийн нийт зардлыг дээрх хэсгүүд тус бүрээр тооцож нэгдсэн зардлыг тооцож гаргалаа.

Нөхөн сэргээлтийн ажлын хамрах хүрээ

Төсөл хэрэгжүүлэгч нь техникийн нөхөн сэргээлтийг өөрсдөө хийж гүйцэтгэх ба харин биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх юм. Тус төсөл нь ашиглалтын хугацаа бага /4 жил/ ба ашиглалтын жилүүдэд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх ба 5 дахь жилд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгүүлнэ. Нөхөн сэргээлтэд дараах объектууд хамаарна. Үүнд:

1. Ил уурхайн ухаш
2. Хурдас чулуулгийн овоолго
3. Асгадас, далан, суваг шуудуу
4. Ахуйн хог хаягдлын байгууламж
5. Уурхайн дотоод, гадаад тээврийн замууд
6. Уурхайн барилга, байгууламжууд

БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалын хавсралтад зааснаар БОМТ-г 5 жилээс дээшгүй хугацаатай төлөвлөх шаардлагатай юм. Иймд “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн нөхөн сэргээлтийн ажлыг БОННУ ажлын хүрээнд 2023 онд хийх уурхайлалтын ажилтай холбож төлөвлөлөө.

Хүснэгт Нөхөн сэргээлтийн ажлын зардлын хэмжээ

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгж зардал /жилд, мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|--|--|---|--|-----------------------------|--|--------------------------------|--|
| 1 | Уурхайн хаалтын нөхөн сэргээлт хөдөө аж ахуй, малын бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээх | Техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ | <ul style="list-style-type: none"> Ил уурхайн карьер Хайгуулын канав | 33 400.0 | *Техникийн нөхөн сэргээлтийг 2 дахь жилээс эхлүүлнэ. | 2023 он | MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт Техникийн шаардлага |
| 2 | | Биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ | <ul style="list-style-type: none"> Гадаад овоолгын талбай Асгадасын талбай | 15 200.0 | | | |
| 3 | | Нөхөн сэргээлтийн хяналт мониторинг | <ul style="list-style-type: none"> Баяжуулах цех Уурхай дээрх барилга байгууламж Тээврийн зам | 4 860.0 | | | |
| 4 | Орчны тохижилт, ногоон байгууламж | Хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай хуулийн 7.2.4 зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийн талбайн 10 хувиас доошгүй талбайг мод тарьж, ургамалжуулах | Тусгай зөвшөөрлийн талбайн 10 хувь буюу 2.5 га талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх | 300.0 | 300.0 | 2023 он | MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт |
| | | | Ногоон байгууламжийн арчилгаа бордоо хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажиллах хүч | 60.0 | 60.0 | 2023 он | MNS 4919:2000 Байгаль орчин, эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага |
| | | | Ногоон байгууламжийн мод, зүлэг услах | 20.0 | 20.0 | 2023 он | MNS 0017-5-1-13:1980 Эвдэрсэн газрын сэргээн сайжруулалт. Нэр томьёо, тодорхойлолт |
| 5 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран, газар заалгаж мод тарих | Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлэх | Материалын шууд зардал /хашаа хайс татах/ | 1 000.0 | 1 000.0 | 2023 он | MNS 0017-5-1-19:1992 Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага |
| | | | Модны арчилгаа бордоо хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажиллах хүч | 200.0 | 200.0 | 2023 он | MNS 0017-5-1-18:1983 Сэргээн сайжруулалт. Эвдэрсэн газрын ангилал |
| | | | Ногоон байгууламжийн мод, зүлэг услах / Жилд 6 сар, Сард 4 удаа услана гэж тооцов/ | 100.0 | 100.0 | 2023 он | MNS 5994:2009 Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага |
| | | | | | | | |
| 2023 оны нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө Нийт зардал (мян.төг) | | | | | | | 2 680.0 |

5.1.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт . Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгж зардал /жилд, мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|--|--|-----------------------------|-----------------------|--------------------------------|--|
| 1 | Төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ | “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн үйл ажиллагаанаас биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран эвдэгдэж орхигдсон талбайг нөхөн сэргээх ажлыг үйл ажиллагааны үед төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай. (Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ болон мөнгөн дүнг Нөлөөлөл бууруулах загвар программ /MDT/ программ хангамж ашиглан тооцсон болно.) | Хэрлэн сумаас хойд зүгт 5 км-т байрлах 1995 оноос өмнө Барилга угсралтын ажилд шаардагдах шороог өмнө олон жил ашиглаж байснаас үүссэн 2 м дундаж гүнтэй, 1.5 га эвдэгдэж, орхигдсон талбайг нөхөн сэргээх | 2 760.94 | 2 760.94 | 2023 он | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 3.1.11-р зүйл, 8.4.6-р зүйл, 9.6-р зүйл |
| 2023 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт зардал (мян.төг) | | | | | 2 760.94 | | |

5.1.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө

Хүснэгт . Нийгэм-эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Нэгжийн өртөг (мян.төг) | Зардал, мян.төг | Хариуцагч |
|--|--|---------|--|-----------------|--------------------|
| 1 | Нөлөөлөлд өртөгч айл өрхүүдийн төлөөлөлтэй уулзах, уулзалт зохион байгуулах, нөлөөллийн талаарх мэдээллийг өгч, саналыг сонсох | 2023 он | - | 100.0 | Төсөл хэрэгжүүлэгч |
| 2 | Засаг дарга, ИТХ-ын гишүүдтэй зөвлөлдөн уурхайн ашиглалтын ажлын үед нөлөөлөлд өртөх айл өрхийг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх | 2023 он | Удирдлага зохион байгуулалтын хүрээнд | | Төсөл хэрэгжүүлэгч |
| 3 | Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй хүлээн авч зохих хэмжээнд нь шийдвэрлэж заавал хариу өгөх. | | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан | | Төсөл хэрэгжүүлэгч |
| Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардлын нийт дүн | | | | 100.0 | |

5.1.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн талбайд тархах бусад хурдаснаас эртний ургамал, амьтны үлдвэр ажиглагдаагүй боловч цаашдын уурхайн нэвтрэлтийн явцад тодорхой гүнд протерозойн цаг үеийн амьтны үлдвэр агуулагч шохойн чулуу илрэх боломжтой юм.

Иймд уурхайн үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ажлаа зогсоож “Соёлын өвийг хамгаалах хууль”-ийн дагуу сум, дүүргийн удирдлага, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэж мэргэжлийн мониторинг хийлгэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах шаардлагатай.

5.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.


Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал, болон барилгажилтын үе шатанд барилгын хог хаягдал гарах ба үүнээс хатуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ялгаж тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллана.

Энгийн хог хаягдлын менежмент: Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр

сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглах шаардлагатай.



Зураг 5.1. Хог хаягдлын цэгийн шийдэл

Төслийн талбайд байгуулах Хог хаягдлын цэгийг Зураг 5.1-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

Хүснэгт . Ангиан ялгах хог хаягдлууд

| Энгийн хог хаягдал | Дахивар хог хаягдал | Аюултай хог хаягдал |
|--|---|---|
| <ul style="list-style-type: none"> ✓ Хоолны үлдэгдэл; ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл; ✓ Яс; ✓ Хэрэглэсэн хүнсний тос ✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал | <ul style="list-style-type: none"> ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/ ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/ ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл; ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/; ✓ Лааз; ✓ Мод, модон эдлэлийн хаягдал; ✓ Хувцас, даавуун эдлэл; ✓ Савхи, резин; ✓ Өвс, мод. | <p>Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ. Иймд төслийн талбайн машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.</p> |

Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага

2.3.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.

2.3.2. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

2.3.3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах

зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.

- a. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.
- b. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.
- c. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- d. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.
- e. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.
- f. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.
- g. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

2.3.4. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

- a. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;
- b. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;
- c. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

2.3.5. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

Хүснэгт . Хог хаягдлын менежментийн зардал

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|--|---------------------------|------------------------|----------------------|--------------------------------|---|
| 1 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжүүлж ажиллах. | Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны туршид | - | - | 2023 онд | Хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 зүйл, 13.1.6 зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам |
| 2 | Хогийг ангилах ялгах, цэгийг сайжруулах, байнгын арчилгаа тордолт хийх, талбайн зонхилох салхины доод талд багтаамж сайтай хогийн сав байршуулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах. | Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны туршид | 300.0 | 300.0 | 2023 онд | |
| 3 | Талбай болон ажлын байрыг тогтмол цэвэрлэж байх. Ажилчдыг цэвэрлэгээний бодис хэрэглэлээр байнга хангаж байх хэрэгтэй. | Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны туршид | 200.0 | 200.0 | 2023 онд | |
| 5 | Аюултай хог хаягдал /Засварын цех болон машины тос, тосолгоо, газрын тос, нефтиэр бохирдсон зүйлс/ | Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны туршид | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | |
| 7 | Аюултай хог хаягдал /Цар тахлын үед гарах хог хаягдал/ | Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны туршид | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 онд | |
| 2023 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал | | | | | | 500.0 | |

5.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт . Осол эрсдэлийн менежментийн зардал

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Арга хэмжээний цар, хүрээ | Нэгжийн өртөг, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|-----------------------------|------------------------|----------------------|--------------------------------|---|
| 1 | Цаг уурын урьдчилсан мэдээллийг авч, үйл ажиллагаатайгаа уялдуулах | Төслийн үйл ажиллагааны үед | 100.0 | 100.0 | 2023 он | <ul style="list-style-type: none"> - MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги - MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага - MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага |
| 2 | Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр төлөвлөн тусгах | Төслийн үйл ажиллагааны үед | Дотоод төлөвлөгөөгөөр | | 2023 он | |
| 3 | | | | | | |



“ДИ ЖИ ТИ ЭНД ЭМ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | | | | |
|---|---|-----------------------------|---|---------|--|
| | Аюул ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээнүүдийн талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах | Төслийн үйл ажиллагааны үед | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан. | 2023 он | <ul style="list-style-type: none">- MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага- MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага- MNS 5247:2003 Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн цогцолбор |
| 2023 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал | | | | | 100.0 |

5.1.8. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- ✓ Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- ✓ Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- ✓ Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт
- ✓ Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг Хэнтий аймгийн БОАЖГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, Онцгой байдлын газар /ОБГ/, Мэргэжлийн хяналтын газар /МХГ/ зэрэг байгууллагуудаар төслийн үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол аварггүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөжөө.

Хүснэгт . Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал | Хэрэгжүүлэх хуваарь | Хариуцагч | Баримтлах стандарт, аргачлал |
|--|--|---------------|-------------|---------------------|-----------|--|
| 1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах | | | | | | |
| 1 | БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх | Дотоод зардал | | 2023 он | Удирдлага | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31.7 дугаар заалт |
| 2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх | Дотоод зардал | | 2023 он | ХАБЭА | “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14.1.2-р заалт |
| 3 | Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хог хаягдлыг аль болох дахин ашиглах, дахин боловсруулах /гэрээ байгуулах/ | Дотоод зардал | | 2023 он | ХАБЭА | “Хог хаягдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, 2017 |
| 4 | Хэнтий аймгийн Онцгой байдлын газраар Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах /үйл ажиллагаа эхлэхээс өмнө/ | Дотоод зардал | | 2023 он | Удирдлага | Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6-р зүйл, 19-р зүйлийн 19.2, 23-р зүйлийн 23.2 |
| 5 | Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Ажлын байрны дүгнэлт гаргуулах /үйл ажиллагаа эхлэхээс өмнө/ | Дотоод зардал | | 2023 он | Удирдлага | Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолын хавсралт |
| 6 | Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулах | Дотоод зардал | | 2023 он | Удирдлага | Газрын тухай хуулийн 58.5-р заалт |
| 2. Ажиллагсдыг чадавхжуулах | | | | | | |
| 7 | Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах, чадавхжуулах | 150.0 | 150.0 | 2023 он | Удирдлага | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27.3.4, 28.1.8-р заалт “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 13.6 |
| 8 | Орон нутгийн онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар сургалт зохион байгуулах | 200.0 | 200.0 | 2023 он | ХАБЭА | “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм” MNS 4969:2000 |

| | | | | | | |
|---|---|---------------|-------|---------|--------------------|---|
| 9 | Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх | 200.0 | 200.0 | 2023 он | ХАБЭА | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14-р зүйл |
| 10 | Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах | Дотоод зардал | | 2023 он | ХАБЭА Удирдлага | |
| 11 | Ажилчдыг үзлэгт хамруулах | Дотоод зардал | | 2023 он | Удирдлага | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14-р зүйл |
| 2023 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал | | | | | | 550.0 |

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д “Төлөвлөгөөт аудитыг хоёр жил тутамд, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ” хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.

Хүснэгт . Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Зардал, сая.төг | Хариуцагч |
|-------------|---|----------------------|-----------------|-----------------------|
| 1 | “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийлгэх | 2024 оны 1-р улиралд | 5 000.0 | Төсөл хэрэгжүүлэгч |
| | | 2026 оны 1-р улиралд | 5 000.0 | |
| Нийт | | | 10 000.0 | |

5.1.9. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт . БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь


| БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Зардал (мян.төг) |
|---|-------------------------------|--|---------------|------------------------------------|------------------|
| Сумын ИНХ | Уулзалт, санал асуулга | БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах | 11-р сар | Нутгийн иргэдийн саналыг хавсаргах | 200.0 (жилд) |
| БОАЖЯ-ны ХБОБНУГ-т | - | Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх | 12-р сар | - | - |
| Нийт | | | | | 200.0 |

5.2. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

“Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн явцад БОННУ-ний тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгав.

БОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа БОХТ-г улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно.

Хяналт-шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, сум, багийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.



Зураг . ОХШХ хэрэгжүүлэх байршил

Хүснэгт . Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задаргаа

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Шаардагдах зардал (мян.төг) | Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---------------------------------|---|---|-------------------------------------|--|---|
| 1. Агаарын чанар | | | | | |
| 1.1 | Агаарт хаягдах түгээмэл бохирдуулагчид(NO ₂ , SO ₂ , CO)-ын агууламжид хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх | Төслийн талбайн 2 цэгт /Далд уурхайн ам, ажилчдын кемп/ | Жилд 2 удаа /4-р сар, 9-р саруудад/ | 1 жил*100.0 мян.төг/жил= 100.0 | <ul style="list-style-type: none"> ❖ MNS 4585: 2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага ❖ MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага ❖ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага ❖ MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ |
| 1.2 | Агаарын тоос, тоосонцрын (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | | | 1 жил*100.0 мян.төг/жил= 100.0 | |
| 1.3 | Дуу шуугиан, чичиргээ | | | 1 жил*50.0 мян.төг/жил =50.0 | |
| | | | | Нийт= 250.0 | |
| 2. Усны хяналт шинжилгээ | | | | | |
| 2.1 2.2 | Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар | Ундны усны дээжлэлт | Жилд 2 удаа | 1 жил*2*150.0 мян.төг/жил= 300.0 | <ul style="list-style-type: none"> ❖ MNS 0900: 2018, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ ❖ MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 10523-2:2003 рН тодорхойлох ❖ MNS ISO 4889-99 Цахилгаан дамжуулах чанар тодорхойлох <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 6059:2005 Хатуулаг тодорхойлох ❖ MNS ISO 2572-99 Кальци тодорхойлох ❖ MNS ISO 9297:2005 Хлорид, тодорхойлох ❖ MNS 4425:97 Гидрокарбонат тодорхойлох тавих хяналт |
| 3. Хөрсний бохирдол | | | | | |
| 3.1 | Хөрсний үржил шимийн үзүүлэлт (рН, ялзмаг, карбонат, Ca ²⁺ Mg ²⁺ , K ₂ O, P ₂ O ₅) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд Cr, Pb, Cd, Ni Zn | Төслийн талбайн 2 цэгт | Жилд 2 удаа /4-р сар, 9-р саруудад/ | Механик бүрэлдэхүүн 49.0 Хүнд металл: 30.0 (Ханлаб ХХК-ийн үнэ болно.) Нянгийн үзүүлэлт 30.0 (ШУА-ийн Ерөнхий болон Сорилын Биологийн | <ul style="list-style-type: none"> ❖ MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ❖ MNS 3310:91, Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох ❖ MNS 3298:1990 хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага ❖ MNS 3307:91, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга ❖ MNS ISO 10390, Хөрсний чанар. рН тодорхойлох ❖ MNS 4006:1988, Хөдөлгөөнт фосфор, калийг |

| | | | | | |
|--|---|---------------------------|----------------|--|--|
| | | | | Хүрээлэнгийн үнэ болно.) Нийт: 436.0 | тодорхойлох ❖ MNS 2143:2000, Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох арга |
| 4. Ургамал | | | | | |
| 4.1 | Ургамлын төрөл, зүйл, бүрхэц, түүний хомсдолт, доройтлын зэрэглэл, бодгалийн тоо, дундаж өндөр, биомасс | Төслийн талбайн 2 цэгт | Жилд 1 удаа | 500.0 | ❖ MNS ISO 11269-1:2002, MNS ISO 11269-2:2002 Хөрсний чанар. Хөрсний ургамлын бохирдолтын нөлөөллийг тодорхойлох. 1, 2-р хэсэг ❖ MNS 5546: 2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага. |
| ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2023 НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | | | | | 1 486.0 мян.төг |

5.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт . Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны нийт зардал

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд | Нийт зардал (мян.төг) |
|--|---|--------------------------|
| 1 | Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1 500.0 |
| 2 | Нөхөн сэргээлт, Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө | 2 680.0 |
| 3 | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 2 760.94 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 100.0 |
| 5 | Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 100.0 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 500.0 |
| 8 | Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал | 550.0 |
| 9 | БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | 200.0 |
| 10 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт зардал | 1 486.0 |
| 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /урьдчилсан байдлаар/ | | 9 876.9 |



ДИ ЖИ ТИ ЭНД ЭМ ХХК-НИЙ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

| | |
|---|--|
| Хянасан огноо | |
| Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар | |
| Дүгнэлт: Шийдвэрийн төсөл Ололт, амжилттай тал Дутагдалтай сул тал Шаардлага | |

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|---|--|
| 1.1 | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр | Ди Жи Ти энд Эм” ХХК |
| | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар | 9011483108 |
| | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл | Гадаад худалдаа |
| | 4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6 бичил хороолол, Хасбаатар, 24, 106, |
| | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | П. Хурцбилэгт |
| 1.2 | 1. Төслийн нэр | “Булган уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төсөл |
| | 2. Төслийн харьяаллын байршил | Хэнтий аймгийн Хэрлэн сум |
| | 3. Төслийн ангилал | Уул уурхай |
| | 4. Төсөл эхэлсэн огноо | 2023 он |
| | 5. Төсөл хэрэгжих хугацаа | 2023 он |
| | 6. ШХЦЦ-ийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт | - |
| | 7. Зураг төсөл баталсан он | 2019 он |

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|---|--|
| 2.1 | 1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай | - |
| | 2. Тусгай зөвшөөрлийн төрөл Дугаар Хүчинтэй хугацаа | -Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл -MV-013378 - 30 жил |
| | Ажлын байрны дүгнэлт | - |
| | 4. Галын дүгнэлтийн огноо, дугаар | |
| | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлах хуулийн этгээд | БОАЖЯ |
| | 7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо | 2022 он |
| | 8. Газар ашиглалтын гэрээний огноо, хуулийн этгээд | |

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|--|-------------------------|
| 3.1 | Шатахуун хадгалах савны багтаамж /хэмжих нэгж/ | - |
| | Шатахууны менежментийн төлөвлөгөө | - |



“ДИ ЖИ ТИ ЭНД ЭМ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | |
|-----|---|---|
| 3.2 | Шатах тослох материалын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх | - |
| | Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ | - |
| 3.3 | Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ Аюултай хог хаягдал | |
| | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай жилийн арга хэмжээний төсөв | |

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд | Нийт зардал (мян.төг) |
|----|--|-----------------------|
| 1 | Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1 500.0 |
| 2 | Нөхөн сэргээлт, Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө | 2 680.0 |
| 3 | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 2 760.94 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 100.0 |
| 5 | Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 100.0 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 500.0 |
| 8 | Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал | 550.0 |
| 9 | БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | 200.0 |
| 10 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт зардал | 1 486.0 |
| | 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /урьдчилсан байдлаар/ | 9 876.9 |

**ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

| Нөлөөллийн ангилал | А. Тооцсон эсэх | Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх | В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх | Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх | Дүгнэлт |
|---|-----------------|--|---|--|---|
| 5.1 Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Эвдрэх -Доройтуулах | Тооцсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тусгай зөвшөөрөл бүхий 25 га талбайн хөрсний судалгаа хийж, төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлсон. |
| 5.2 Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Нөөцийг бууруулах | Тооцсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Шатахууны хадгалалтаас хөрсний капилляраар дамжин сүвийн даралтаар тэнцвэрдэн гүний усыг бохирдуулах боломжтой. |
| 5.3 Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл -Амьдрах орчныг хуваах -Амьдрах орчныг - хомсдуулах -нөөцийг бууруулах | Тооцсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Өнгөн хөрсийг хуулснаар үүдсэн экологийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс зарим зүйлийн шавьжийн тоо толгой буурах, өсөн нэмэгдэж болзошгүй. |
| 5.4 Агаарт үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Тоос | Тооцсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Уурхайн дотоод болон гадаад тээврийн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоос босох |
| 5.5 Түүх соёлын дурсгалт эд зүйлс -Хамгаалах -Нүүлгэн шилжүүлэх | Тооцсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | Тодорхойлсон | - |

ЗУРГАА. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

| Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл | А. Тоо | Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх | В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх | Г. Дүгнэлт |
|--|----------------|---------------------------------------|--|---|
| 6.1. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ | 5 | Тийм | Тийм | Агаар, газрын гадарга, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал, амьтан, нийгмийн чиглэлээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөсөн |
| 6.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 3 | Тийм | Тийм | |
| А. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/ га эзлэхүүн - биологийн/ га | Талбайн орчимд | Тийм | Тийм | Талбайн захыг эмжээрлэн мод, сөөг тарих |
| 6.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ | - | Тийм | Тийм | Төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу холбогдох ажилтан албан хаагч тайлагнах |
| 6.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | - | - | - | |
| 6.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 4 | Тийм | Тийм | |

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

| Хяналт шинжилгээний дээж | А. Дээж авах цэгийн тоо | Б. Дээж авах цэгийн байршил | В. Давтамж | Г. Төсөв (Мянган төгрөг) |
|--------------------------|-------------------------|---|-------------|--------------------------|
| Хөрс | 2 | Төслийн талбайн 2 цэгт | Жилд 2 удаа | 300.0 |
| Агаар | 2 | Төслийн талбайн 2 цэгт /Далд уурхайн ам, ажилчдын кемп/ | | 250.0 |
| Ус | 1 | Унд ахуйн уснаас | | 436.0 |